

Хэрэглэгчдэд зориулсан эм хэрэглэх заавар

Фенкарол 10мг шахмал

Фенкарол 25мг шахмал

Хифенадин

Танд зориулсан чухал мэдээлэл агуулсан тул эмийн бэлдмэлийг хэрэглэхийн өмнө зааврыг сайтар уншина уу.


- Зааврыг хадгал. Танд дахин унших хэрэг гарч болно.
- Хэрэв танд ямар нэг асуулт байвал эмч, эм зүйчээс лавлана уу.
- Энэ эмийг зөвхөн таньд зориулан жоронд бичсэн. Бусдад дамжуулж болохгүй. Хэдийгээр тэдэнд тантай ижил шинж тэмдэг илэрсэн ч бусдад аюултай нөлөө үзүүлж болзошгүй.
- Хэрэв танд аль нэг гаж нөлөө илэрвэл эмч, эм зүйчид мэдэгдэнэ. Үүнд зааварт тусгагдаагүй гаж нөлөө байж болно. 4-р хэсгийг үзнэ үү.
- Хэрэв эм хэрэглээд 2-3 хоногийн дараа таны биеийн байдал сайжрахгүй, эсвэл өвчин хүндэрч байвал эмчээсээ зөвлөгөө авах хэрэгтэй.

Агуулга

1. Фенкарол гэж юу вэ, юунд хэрэглэх вэ
2. Фенкаролыг хэрэглэхийн өмнө мэдвэл зохих зүйлс
3. Фенкаролыг хэрхэн хэрэглэх вэ
4. Боломжит гаж нөлөө
5. Фенкаролыг хэрхэн хадгалах вэ
6. Савалгааны агууламж ба бусад мэдээлэл

1. Фенкарол гэж юу вэ, юунд хэрэглэх вэ

Энэхүү эмийн бэлдмэл нь гистамины эсрэг эмийн бодисын бүлэгт хамаарагдах (харшлын урвалын эмчилгээнд хэрэглэдэг) хифенадин гидрохлорид (цаашид хифенадин гэнэ) гэдэг нэгдэл агуулдаг. Хифенадин нь өвөрмөц үйлдлийн механизмтай бөгөөд гистамины эсрэг бусад эмийн бэлдмэл үйлчилдэггүй



өвчтөнүүдийн үед эмчилгээний үр дүн сайтай байдаг. Хифенадин төв мэдрэлийн тогтолцоог (ТМТ) саатуулах нөлөө үзүүлдэггүй, гэхдээ ховор тохиолдолд хөнгөн зэргийн тайвшруулах нөлөө үзүүлж болно.

Дараах тохиолдолд фенкаролыг хэрэглэнэ:

- Цэцгийн тоосны харшил
- Цочмог болон архаг явцтай чонон гүвдрүү
- Ургамлын харшил
- Харшлын ринит
- Харшлын конъюнктивит
- Судаслаг хаван
- Дерматозууд (экзем, нейродерматит, загатнаа зэрэг)
- Хоол болон эмийн гаралтай харшлын урвалууд

2. Фенкаролыг хэрэглэхийн өмнө мэдвэл зохих зүйлс

Дараах тохиолдолд Фенкаролыг хэрэглэхийг хориглоно:

- хэрэв та хинидин гидрохлорид эсвэл энэ эмийн бэлдмэлийн найрлаганд байгаа аль нэг нэгдэлд харшилтай бол (6-р хэсэгт бичигдсэн байгаа)
- хэрэв та жирэмсний эхний 3 сартай бол. Фенкаролыг жирэмсний бүхий л хугацаанд хэрэглэхгүй байх хэрэгтэй.
- Хэрэв та хүүхэд хөхүүлдэг бол

Анхааруулга ба сэрэмжлүүлэг

Дараах тохиолдолд Фенкарал хэрэглэхийн өмнө эмчлэгч эмчтэй зөвлөх хэрэгтэй:

- Хэрэв та зүрх болон судасны хүнд хэлбэрийн өвчтэй бол
- Хэрэв та хүнд хэлбэрийн хоол боловсруулах замын өвчтэй бол
- Хэрэв та хүнд хэлбэрийн элэг болон/эсвэл бөөрний өвчтэй бол

Хүүхэд ба өсвөр үеийнхний хэрэглээ

Эмийн хэлбэртэй холбоотой Фенкарал шахмалыг 2 хүртэл насны хүүхдэд хэрэглэж болохгүй.

Фенкарал болон бусад эмийн бэлдмэлийн харилцан үйлчлэл



Хэрэв та өөр ямар нэгэн эм хэрэглэж байгаа, хэрэглэсэн, эсвэл хэрэглэхээр төлөвлөж байгаа бол энэ талаар эмч болон эм зүйчид мэдэгдэж зөвлөгөө авна уу. Фенкарол ховсын төв мэдрэлийн тогтолцоог дарангуйлах нөлөөг дэмждэггүй. Энэ эмийн бэлдмэл нь хоол боловсруулах замын хөдөлгөөнийг (гүрвэлзэх хөдөлгөөн) бууруулж болох ба удаан шимэгддэг эмийн бэлдмэлийн шимэгдэлтийг дэмжиж болзошгүй (жишээ нь шууд бус антикоагулянт - кумаринууд).

Фенкаролыг хоол, унд, архи согтууруулах ундтай хамт хэрэглэх нь

Хифенадин болон хоолны харилцан үйлчлэлийг судлаагүй байна.

Фенкарол архи согтууруулах ундааны төв мэдрэлийн тогтолцоог дарангуйлах нөлөөг дэмждэггүй.

Жирэмсэн ба хөхүүл үеийн хэрэглээ

Хэрэв та жирэмсэн эсвэл хүүхэд хөхүүлдэг, жирэмсэн байж магадгүй эсвэл жирэмслэхээр төлөвлөж буй тохиолдолд энэхүү эмийн бэлдмэлийг хэрэглэхийн өмнө эмч болон эм зүйчээс зөвлөгөө авах хэрэгтэй.


Хэрэв та жирэмсний эхний 3 сартай бол фенкаролыг хэрэглэж болохгүй. Фенкаролыг жирэмсний бүхий л хугацаанд хэрэглэхгүй байх хэрэгтэй ("Фенкаролыг хэрэглэж болохгүй" заалтыг уншина уу).

Хифенадин эхийн хөхний сүүгээр гадагшилдаг эсэх тогтоогдоогүй тул фенкаролыг хөхүүл үед хэрэглэхийг хориглодог ("Фенкаролыг хэрэглэж болохгүй" заалтыг уншина уу).

Авто тээврийн хэрэгсэл жолоодох болон машин механизм ажиллуулах чадварт нөлөөлөх нөлөө

Оюуны болон биеийн урвалын хурд шаардсан ажил мэргэжил эрхэлдэг хүмүүст (жолооч) энэхүү эмийн бэлдмэл нь тайвшруулах, нойрсуулах нөлөө үзүүлдэг эсэхийг энэ эмийн бэлдмэлийг богино хугацаанд хэрэглэж сайтар ажиглах хэрэгтэй. Хэрэв тийм нөлөө илэрч байвал ийм хүмүүс машин жолоодох эсвэл ажиллахаас татгалзах хэрэгтэй.

Фенкарол сахар агуулдаг



Хэрэв эмч танд ямар нэг сахарын үл тэвчилтэй гэж хэлж байсан бол энэхүү эмийн бэлдмэлийг хэрэглэхийн өмнө эмчлэгч эмчтэй зөвлөлдөнө үү.

3. Фенкаролыг хэрхэн хэрэглэх вэ

Эмийн бэлдмэлийг энэ зааварт бичсэнээр эмч, эм зүйчийн зааврыг ягштал баримтлан хэрэглэнэ. Хэрэв та итгэлгүй бол эмч, эм зүйчээс асуугаарай.

Фенкаролыг хоолны дараа уух хэрэгтэй.

Фенкарол 25мг шахмал

Насанд хүрэгсэд: нэг удаагийн тун 25-50мг-аар өдөрт 2-4 удаа хэрэглэнэ. Хоногийн хамгийн дээд тун 200мг байна.

Өсвөр үеийнхэнд (12-18 насны): 25 мг-аар өдөрт 2-3 удаа хэрэглэнэ.

Ээлж эмчилгээний үргэлжлэх хугацаа 10-20 өдөр байна. Хэрэв шаардлагатай бол ээлж эмчилгээг давтан хийж болно.

Хүүхэд болон өсвөр үеийнхний хэрэглээ

Фенкарол 10мг шахмал

Шахмалыг ижил тэнцүү тунд хувааж болно.

Энэ эмийн бэлдмэлийг 3 хүртэл насны хүүхдэд зөвхөн эмчтэй зөвлөлдсөний дараа л хэрэглэх хэрэгтэй.

2-3 насны хүүхдэд: тун нь 5мг (1/2 тал шахмал) өдөрт 2-3 удаа хэрэглэнэ.

3-7 насны хүүхдэд: тун нь 10мг (нэг шахмал) өдөрт 2 удаа хэрэглэнэ.

7-12 насны хүүхдэд: 10 – 15мг-аар (1-1 ½ шахмал) өдөрт 2-3 удаа хэрэглэнэ.

Өсвөр насны хүүхдүүдэд (12-18 нас) фенкаролыг 25мг-ын шахмалыг хэрэглэхийг зөвлөдөг.

Ээлж эмчилгээг 10-15 хоног хийхийг зөвлөдөг. Хэрэв шаардлагатай бол ээлж эмчилгээг давтан хийж болно.

Хэрэв фенкаролын эмчилгээний үр нөлөө сулхан эсвэл хэтэрхий хүчтэй санагдвал эмчлэгч эмч болон эм зүйчээс зөвлөгөө аваарай.

Хэрэв Фенкаролын тунг хэтрүүлж хэрэглэсэн бол



Хэрэв та фенкаролын тунг хэтрүүлэн олон шахмал хэрэглэсэн бол шууд эмчид хандах хэрэгтэй. Тун хэтэрсэн үеийн шинж тэмдэг нь: салст хуурайших, толгой өвдөх, бөөлжих, аюулхайд өвдөх, биж.

Хэрэв фенкаролын тунг уухаа мартсан бол

Алгассан тунг нөхөх зорилгоор тунг давхарлан ууж болохгүй.

Хэрэв Фенкарол эмийг хэрэглэхээ зогсоох бол

Хэрэв цаашид энэ эмийн бэлдмэлийн хэрэглээтэй холбоотой асуудал үүсвэл эмч, эм зүйчээс асуугаарай.

4. Боломжит гаж нөлөө

Бусад эмийн бэлдмэлийн нэгэн адил гаж нөлөө илэрч болох хэдий ч бүх хүнд илрэх албагүй.

Элбэг (100 хүний 1/10 хүртэл хүнд илэрч болно): ам хатах.

Хаяа (1000 хүний 1/10 хүртэл хүнд илэрч болно): толгой өвдөх, нойрмоглох, хоол боловсролт муудах (дотор муухайрах, бөөлжих) зэрэг шинжүүд нь эмийн тунг бууруулах эсвэл зогсооход ихэнхдээ арилдаг.

Гаж нөлөөний урвалуудын аль нэг шинж тэмдэг хүндэрвэл эсвэл энэхүү зааварт бичигдээгүй гаж нөлөөний урвал илэрвэл эмчлэгч эмчдээ хандаж зөвлөгөө авах хэрэгтэй.

5. Фенкаролыг хэрхэн хадгалах вэ

25°C ихгүй хэмд хадгална.

Гэрлийн тусгал, чийгнээс хамгаалан өөрийн саванд хадгална.

Эмийг хүүхэд хүрэхгүй газарт хадгална.

Цаасан хайрцагт заасан хугацаа дууссан бэлдмэлийг хэрэглэхгүй.

Үүнд дуусах хугацааны сар, өдрийг бичсэн байна. Хүчинтэй хугацаа нь тухайн сарын сүүлийн өдрийг заана.

Үлдсэн хэсгийг ахуйн хог хаягдал, бохир усанд бүү устга. Удаан хугацаанд хэрэглээгүй эмийг хэрхэн устгах талаар эм зүйчээс асуу. Ингэснээр байгаль орчноо хамгаалахад туслах болно.



6. Савалгааны агууламж ба бусад мэдээлэл

Фенкаролын найрлага:

- Идэвхитэй үйлчлэгч бодис нь хифенадин гидрохлорид.

Фенкарол 10мг шахмал нь 10 мг хифенадин гидрохлорид агуулна.

Фенкарол 25мг шахмал нь 25 мг хифенадин гидрохлорид агуулна.

- Найрлага дахь бусад нэгдлүүд: сахароз, төмсний цардуул, кальцийн стеарат.

Фенкаролын дүрслэл ба савлалт

Фенкарол 10мг шахмал:

Цагаан эсвэл бараг цагаан өнгийн, дугуй, хавтгай, налуу ирмэгтэй, нэг гадаргуу дээрээ хуваах хэрчдэстэй шахмал.

Фенкарол 25мг шахмал:

Цагаан эсвэл бараг цагаан өнгийн, дугуй, хавтгай, налуу ирмэгтэй шахмал.

Фенкарол 10мг ба 25мг шахмалууд нь: тунгалаг поливинилхлорид (PVC) ялтас болон хөнгөн цагаан фольгагаар хийсэн блистерт 10 ширхэг шахмал савласан байна. 2 блистерийг (20 шахмал) эм хэрэглэх зааврын хамтаар хатуу цаасан хайрцагт савласан байна.

Маркетингийн зөвшөөрөл эзэмшигч ба үйлдвэрлэгч

Компанийн нэр: Joint-Stock Company "OLAINFARM"

Хаяг: 5, Rupnicu St., Olaine, LV-2114, Latvia.

Утас: +371 67013705

Fax +371 67013777

e-mail: olainfarm@olainfarm.lv



Хэрэглэгчдэд зориулсан эм хэрэглэх заавар

ФЕНКАРОЛ 50мг шахмал

Квифенадин

Энэхүү заавар нь танд хэрэгцээтэй, чухал мэдээлэл агуулсан байгаа тул эмийн бэлдмэлийг хэрэглэж эхлэхийн өмнө анхааралтай уншина уу.

Энэхүү бэлдмэлийг уг зааварт бичсэн удирдамж, эсвэл эмч болон эм зүйч танд зөвлөсөний дагуу хэрэглэх хэрэгтэй.


- Энэхүү зааврыг хадгалаарай. Танд дахин унших хэрэгцээ гарч мэднэ.
- Илүү их мэдээлэл болон зөвлөгөө авах шаардлагатай бол та эм зүйчид хандаарай.
- Хэрэв Танд ямар нэг гаж нөлөө илэрвэл эмч болон эм зүйчдээ мэдэгдэж, зөвлөгөө аваарай. Үүнд энэхүү зааварт дурьдагдаагүй бусад гаж нөлөө ч хамаатай болно. 4-р хэсгийг үзнэ үү.
- Хэрэв эмийн бэлдмэлийг хэрэглээд 2-3 хоногийн дараа таны биеийн байдал сайжрахгүй, эсвэл улам дордоод байвал та эмчид хандаарай.

Энэхүү зааврын агууламж:

- 1.Фенкарол гэж юу вэ? Ямар үед хэрэглэх вэ?
- 2.Фенкарол бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу мэдэж байвал зохилтой вэ?
- 3.Фенкарол бэлдмэлийг хэрхэн хэрэглэх вэ?
- 4.Илэрч болзошгүй гаж нөлөө
- 5.Фенкарол бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?
- 6.Савлагааны агууламж ба бусад мэдээлэл

1. Фенкарол гэж юу вэ? Ямар үед хэрэглэх вэ?

Фенкарол бэлдмэлийн идэвхитэй үйлчлэгч бодис нь квифенадины гидрохлорид (цаашид квифенадин) юм. Энэ нэгдэл нь гистамины эсрэг эмийн бүлэгт хамаарагдана (харшлын эмчилгээний бэлдмэл). Энэ бүлгийн бусад эмийн бэлдмэлтэй харьцуулахад квифенадин нь үйлдлийн хоёр механизмтай. Тийм учраас бусад төрлийн гистамины эсрэг бэлдмэл үйлчилдэггүй хүмүүст энэхүү бэлдмэл үр дүнтэй байдаг. Квифенадин нь төв мэдрэлийн тогтолцоог дарангуйлах нөлөө үзүүлдэггүй. Гэхдээ бага зэргийн тайвшруулах нөлөө зарим тохиолдолд ажиглагдаж болно.



Энэхүү бэлдмэлийг поллиноз (ургамлын харшил), цочмог болон архаг чонон хөрвөс (загатнаат улайлт), харшлын ринит (хамар битүүрэх), харшлын конъюнктивит (зовхины дотор талд нүдний салстын үрэвсэл), судаслаг хаван (ам, хэл, уруул, залгиур хавагнаснаас амьсгалах болон залгихад хүндрэлтэй болох), арьсны гэмтэл (дерматоз, экзем, нейродерматит), арьсны загатнаа, хүнс болон эмийн гаралтай харшлын урвалуудыг эмчлэхэд хэрэглэнэ.

2. Фенкарол бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу мэдэж байвал зохилтой вэ?

Фенкаролыг дараах тохиолдолд хэрэглэхийг хориглоно:

- Хэрэв та квифинадин болон энэ эмийн бэлдмэлийн найрлага дахь аль нэг нэгдэлд харшилтай бол (6-р хэсэгт бичигдсэн),
- Жирэмсний эхний гурван сардаа байгаа (жирэмсний бусад саруудад ч гэсэн энэ бэлдмэлийг хэрэглэхийг зөвлөдөггүй),
- Хэрэв та хөхүүл хүүхэдтэй бол.

Анхааруулга ба сэрэмжлүүлэг

Фенкарол бэлдмэлийг хэрэглэхийн өмнө эмчлэгч эмч болон эм зүйчтэй дараах тохиолдолд ярилцаж зөвлөгөө аваарай:

- Хэрэв та зүрх судасны хурц, цочмог өвчтэй бол
- Хэрэв та хоол боловсруулах замын хурц, цочмог өвчтэй бол
- Хэрэв та элэг ба/эсвэл бөөрний хурц, цочмог өвчтэй бол

Хүүхэд ба насанд хүрэгсэд

Хүүхэд ба насанд хүрэгсэд Фенкарол бэлдмэлийн нэгж тундаа идэвхитэй үйлчлэгч бодисын өөр өөр агууламжтай, хүүхдэд бага тунтай эмийн бодисыг хэрэглэхийг зөвлөдөг.

Фенкарол ба бусад эмийн бэлдмэлүүд

Хэрэв та одоо өөр эмийн бэлдмэл хэрэглэдэг, саявтархан хэрэглэсэн, эсвэл хэрэглэж магадгүй байгаа бол эмчлэгч эмч эсвэл эм зүйчдээ хандах хэрэгтэй.

Фенкарол нь төв мэдрэлийн тогтолцоонд ховсын дарангуйлах нөлөөг ихэсгэдэггүй. Энэ эмийн бэлдмэл нь хоол боловсруулах замын хөдөлгөөний идэвхийг бууруулах болон удаан шимэгддэг эмийн бодисуудын гэдэсний шимэгдэлтийг ихэсгэх (цусны судсанд цусны бүлэн үүсэлтээс хамгаалдаг



бэлдмэлүүд (кумарины төрлийн цус бүлэгнэлтийн эсрэг бэлдмэлүүд)) үйлдэлтэй.

Фенкаролыг хоол болон архи согтууруулах ундаатай хэрэглэх нь

Хоол хүнстэй энэ эмийн бэлдмэлийн харилцан үйлчлэлийн талын судалгаа байхгүй байна.

Фенкарол нь төв мэдрэлийн тогтолцоонд архи, согтууруулах ундааны дарангуйлах нөлөөг ихэсгэдэггүй.

Жирэмсэн ба хөхүүл үеийн хэрэглээ

Хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл хүүхэдтэй, эсвэл жирэмсэн байж магадгүй, эсвэл жирэмслэхээр төлөвлөж буй бол энэ эмийн бэлдмэлийг хэрэглэхийн өмнө эмч болон эм зүйчээс зөвлөгөө авах хэрэгтэй.

Энэ эмийн бэлдмэлийг жирэмсний эхний гурван сартайд хэрэглэж болохгүй. Мөн жирэмсний бусад үеүдэд ч хэрэглэхийг зөвлөдөггүй ("Фенкаролыг хэрэглэж болохгүй заалт"-ыг харна уу).

Квифенадин эхийн хөхний сүүгээр ялгардаг эсэх нь тодорхойгүй байна. Тийм учраас энэ эмийн бэлдмэлийг хөхүүл ээж хэрэглэж болохгүй ("Фенкаролыг хэрэглэж болохгүй заалт"-ыг харна уу).

Машин жолоодох үеийн хэрэглээ

Мэргэжлийн ур чадвар нь ажил үүргээ гүйцэтгэхдээ үйлийн хурд шаардсан ажил эрхэлдэг эмчлүүлэгчид энэ эмийг хэрэглэхэд нойр хүргэж байгаа эсэхийг шалгах үүднээс эмчилгээ эхлэхээс өмнө богино хугацаанд эмийг хэрэглэж үзэх хэрэгтэй. Хэрэв тийм нөлөө үзүүлж байвал энэ эмчилгээний үед жолоо барихаас зайлсхийх хэрэгтэй.

Фенкарол нь сахароз агуулдаг


Хэрэв танд эмч өмнө нь таныг зарим нүүрсусанд үлтэвчилтэй гэж хэлж байсан бол энэ эмийг хэрэглэхээсээ өмнө эмчтэйгээ уулзаж зөвлөгөө авах хэрэгтэй.

3. Фенкарол бэлдмэлийг хэрхэн хэрэглэх вэ?

Энэхүү бэлдмэлийг зөвхөн уг зааварт бичсэн удирдамж, эсвэл эмч болон эм зүйч танд зөвлөсөний дагуу хэрэглэх хэрэгтэй. Хэрэв танд эргэлзээтэй байвал эмч болон эм зүйчтэйгээ зөвлөөрэй.

Фенкаролыг шууд хоолны дараа хэрэглэнэ.

Насанд хүрэгсдэд тун нь 25-50мг, өдөрт 2-4 удаа хэрэглэнэ. Хоногийн хамгийн дээд тун 200мг байна.



Өсвөр үеийнхэнд (12-18 насны) тун нь 25мг, өдөрт 2-3 удаа хэрэглэнэ.

Ээлж эмчилгээний үргэлжлэх хугацаа 10-20 өдөр байна. хэрэв шаардлагатай бол ээлж эмчилгээг давтаж болно.

Хэрэв 25мг тун шаардлагатай бол Фенкарол бэлдмэлийн 25мг-тай шахмалыг хэрэглэх нь зүйтэй.

Хэрэв энэ эмийн бэлдмэлийн үйлчлэл дэндүү хүчтэй, эсвэл хэт сул юм шиг санагдвал та эмчлэгч эмч эсвэл эм зүйчдээ хандаарай.

Хэрэв та Фенкарол бэлдмэлийг хэрэглэх ёстойгоосоо илүү ихээр хэрэглэсэн бол

Хэрэв та Фенкарол бэлдмэлийг хэрэглэх ёстойгоосоо илүү ихээр хэрэглэсэн бол эмчтэйгээ зөвлөлдөөрэй. Их тунгаар хэрэглэсэнээс болж салст бүрхүүл хуурайших, толгой өвдөх, дотор муухайрах, бөөлжих, аюулхайд өвдөх, хоол боловсруулалтын бусад алдагдал илэрч болзошгүй.

Хэрэв Фенкарол бэлдмэлээ хэрэглэхээ мартсан бол

Мартсан тунгаа нөхөж уухын тулд давхар тунгаар хэрэглэж болохгүй

Хэрэв Фенкарол бэлдмэлийг хэрэглэхээ зогсоож байгаа бол

Энэ эмийн бэлдмэлийг хэрэглэх эсэх талаар ямар нэг асуулт байгаа бол эмчлэгч эмч болон эм зүйчдээ хандана уу.

4. Илэрч болох гаж нөлөө

Бусад эмийн бэлдмэлийн нэгэн адил энэ эмийн бэлдмэл нь гаж нөлөө үзүүлж болох ч бүх хүнд адилхан илэрдэггүй.

Элбэг тохиолдох: (10 хүнээс 1 хүртэл хүнд тохиолдоно):


- Ам хатах.

Хаяа илрэх (100 хүнээс 1 хүртэл хүнд тохиолдоно):

- Толгой өвдөх, нойрмоглох;
- Хоол боловсролт алдагдах (дотор муухайрах, бөөлжих), энэ шинж тэмдэг нь ихэнхдээ тун бууруулах болон эмийн хэрэглээг зогсооход арилна.

Гаж нөлөөг мэдээлэх нь

Хэрэв танд ямар нэг гаж нөлөө илэрвэл эмч болон эм зүйчдээ хандаарай. Үүнд энэхүү зааварт дурьдагдаагүй аль ч гаж нөлөө хамаарна. Түүнээс гадна илэрч буй гаж нөлөөг бүртгэх Үндэсний мэдээлэх тогтолцоог ашиглан өөрт илэрсэн гаж нөлөөг мэдээлж болно. Ингэж гаж нөлөөг мэдээлснээрээ та энэхүү эмийн



бэлдмэлийн аюулгүй байдлын талаар илүү мэдээлэл цуглуулахад тусалж байна гэсэн үг юм.

5. Фенкарол бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?

25 °C-аас ихгүй хэмд хадгална.

Гэрлийн шууд тусгал болон чийгнээс хамгаалсан газарт, үйлдвэрлэгчийн савлагаанд нь хадгална.

Хүүхдэд харагдахгүй, гар хүрэхээргүй газар хадгална.

Хатуу цаасан хайрцаг дээр EXP бичиглэлийн ард бичигдсэн хүчинтэй хугацаа хэтэрсэн тохиолдолд энэхүү бэлдмэлийг хэрэглэж болохгүй. Хүчинтэй хугацаа тухайн сарын сүүлийн өдрийг заана.

Аль ч эмийн бодисыг урсгал ус болон ахуйн хогонд хийж хаяж болохгүй. Хэрэглэхээ больсон эмийн бэлдмэлийг хэрхэн устгах талаар эм зүйчээс зөвлөгөө аваарай. Энэ арга хэмжээ нь хүрээлэн байгаа орчноо бохирдуулахаас хамгаална.

6. Савлагааны агууламж ба бусад мэдээлэл

Фенкаролын агууламж:

- Идэвхитэй үйлчлэгч бодис нь квифенадины гидрохлорид юм (*Quifenadini hydrochloridum*).

Нэг шахмал бүрт 50мг квифенадины гидрохлорид агуулагдана.

- Бусад туслах бодис нь төмсний цардуул, сахароз, желатинжуулсан цардуул, кальцийн стеарат байдаг.

Фенкарол бэлдмэлийн дүрслэл ба савлагаан дахь агууламж

Цагаан, бараг цагаан өнгөтэй, дугуй, налуу ирмэгтэй хавтгай шахмал.

Нэг блистерт 15 шахмал агуулагдана.

1 блистер (15 шахмал) эм хэрэглэх зааврын хамтаар хатуу цаасан хайрцагт агуулагдана.

Үйлдвэрлэл ба борлуулалт хариуцсан байгууллага:

JSC "Olainfarm"

5 Rupnicu Str., Olaine, LV-2114, Латви улс

Утас.: +371 67013705

Fax: +371 67013777

e-mail: olainfarm@olainfarm.lv

Энэхүү заавар хамгийн сүүлд хянагдсан огноо: 02/2018

